



# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН З А Х И Р А М Ж

2015 оны 10 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 212

Улаанбаатар  
хот

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн  
шинэчлэн батлах тухай

1. “Тавантолгойн цахилгаан станц” төслийг хэрэгжүүлэх ажлыг удирдлагаар хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавих үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Дарга -Монгол Улсын сайд М.Энхсайхан

Гишүүд: -Эрчим хүчний сайд Д.Зоригт;

-Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл;

-Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэ;

-Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Ш.Раднаасэд;

-Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга С.Доржсэмбэд;

-Эрчим хүчний яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Товуудорж;

-Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Н.Мөнхбат.

Нарийн бичгийн дарга -“Тавантолгойн цахилгаан станц” төслийн захирал Б.Тэмүүжин.

2. “Тавантолгойн цахилгаан станц” төслийн хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг боловсруулах ажлыг удирдан зохион байгуулахыг Монгол Улсын сайд, Ажлын хэсгийн дарга М.Энхсайханд даалгасугай.

3. Төслийн хөрөнгө оруулагчийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж, эрчим хүчний салбарын болон холбогдох төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог ханган ажиллахыг Ажлын хэсгийн гишүүн, Эрчим хүчний сайд Д.Зоригт, Ажлын хэсгийн Нарийн бичгийн дарга Б.Тэмүүжин нарт үүрэг болгосугай.

4. “Тавантолгойн цахилгаан станц” төслийг хэрэгжүүлэх ажлын явц, үр дүнг тухай бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Ажлын хэсэг (М.Энхсайхан)-т үүрэг болгосугай.

5. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Ажлын хэсэг байгуулах тухай” Ерөнхий сайдын 2015 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 159 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ